ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 11 сарын 19 өдөр Дугаар А/176. Дархан

Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох, сунгах, чиглэл нэмэх, нэршил өөрчлөх, зэрэглэл бууруулах, хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэр нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалт, 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 6, 13 дугаар зүйлүүд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 11 дүгээр сарын А/383, А/402 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын 2024 оны 11 дүгээр сарын 15-ний өдрийн №09 хурлын тэмдэглэлийн шийдвэрийг үндэслэн Дархан-Уул аймгийн хэмжээнд "Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох байгууллагын нэрсийн жагсаалтыг нэгдүгээр, хугацаа сунгах байгууллагын нэрсийн жагсаалтыг хоёрдугаар, үйл ажиллагааны чиглэл нэмэх байгууллагын нэрсийг жагсаалтыг гуравдугаар, нэр өөрчлөх байгууллагын нэрсийг жагсаалтыг дөрөвдүгээр, эмийн сангийн зэрэглэл бууруулах байгууллагын нэрсийн жагсаалтыг тавдугаар, хүсэлтийн дагуу тусгай зөвшөөрөл хүчингүй болгох байгууллагын нэрсийг жагсаалтыг зургаадугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтэс (Б.Золбаясах)-д үүрэг болгосугай.

ДАРГА Б.ЭРДЭНЭТУЛГА

4524010624